



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө залруулан бүртгэх, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4, дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 83,683,240.00 (наян гурван сая зургаан зуун наян гурван мянга хоёр зуун дөчин) төгрөгийн балансын үнэтэй, 35459 м.кв талбай бүхий газар буюу биет бус хөрөнгө (газрын эрх)-ийг хэмжилтийн зөрүүний 36 м.кв талбайгаар бууруулж, 35423 м.кв буюу 83,598,280.00 (наян гурван сая таван зуун ерэн найман мянга хоёр зуун наян) төгрөгөөр залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 10,006,400.00 (арван сая зургаан мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (газрын эрх)-ийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасаж, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын данс бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга М.Баяраа болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, залруулан бүртгэх, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд, Нийслэлийн цагдаагийн удирдах газарт эзэмшүүлэх, ашиглуулах, данс бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

137001131

3.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн
240 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ХАНГАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ, БҮРТГЭЛД ТУСГАХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Бүртгэсэн он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Бүртгэлд тусгах хуулийн этгээд
1	Биет бус хөрөнгө (газрын эрх), Баянзүрх, 10 дугаар хороо	2018	2,360.00	м2	4240	10,006,400.00	Нийслэлийн цагдаагийн удирдах газар
	Нийт дүн					10,006,400.00	